

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН “БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛСЭД СУВИЛАГЧ
БИДНИЙ ОРОЛЦОО” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2019

2019 оны 4-р сарын 30.

“ИНЭЭМСЭГЛЭЛ ЭЕРЭГ ХАНДЛАГА” уриатайгаар Өмнөговь аймгаас зарласан “ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” ийн хүрээнд бүх нийтэд чиглэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг 11 тэргүүлэх чиглэлээр тодорхойлон 19 эмнэлгийн 353 сувилагч, мэргэжилтнүүд тасаг, нэгж бүрд төлөвлөлт гарган хэрэгжүүлсэн. Үүнд:

1. **Айл өрхүүдэд гар угаах орчин, ЭКО ариун цэврийн орчин бүрдүүлэх:** 950 (4.3%) айлд үнэлгээ хийж, зөвлөмжөөр ханган сайжруулалт хийн ажиллаж байна.
2. **Хүн амыг аюулгүй цэвэр ундны усаар хангах:** Өмнөговь аймагт нийт 63 худгийг унд ахуй, хөдөө аж ахуй, технологийн зориулалтаар ашигладаг ба эдгээр худгийн 65.1% нь усны чанар сайн, 34.89% нь дунд зэрэг гэсэн судалгааны дүгнэлт хийгдсэн байна. Унд ахуйн хэрэгцээнд ашиглагдаж буй худгуудын 41 (65%) нь эрүүл ахуйн шаардлага хангасан хамгаалалтын бүстэй байсан байна.
3. **Хүн амын хорт зуршил, давсны хэрэглээг бууруулах:** Тус зорилгод нийцсэн 15 арга хэмжээг сувилагч, тусгай мэргэжилтнүүд манлайлан хэрэгжүүлж, 976 иргэнийг хамруулсан.
4. **Иргэдийн дунд хамар, хоолойн ялгадасыг ил задгай хаяхгүй байх соёлыг нэвтрүүлэх:** 30 сургалт, 17 нөлөөллийн ажил зохион байгуулж, 4 төрлийн 6000 орчим сурталчилгааны материал иргэдэд түгээсэн.
5. **Зорилтот бүлэг буюу эмэгтэйчүүд хүүхэд, өндөр настны хяналт, тусламжийг сайжруулах:** Эх хүүхэд аяныг 3 бүсээр явуулж, эцэг эхчүүдийн сургалтад 560 хүн, өдөрлөгт 6000 хүн, Сайн аав, ээж сум бүрээс 3 нийт 51 хүнийг шалгаруулан урамшуулсан.
6. **Үйлчлэх хүрээний айл өрхүүдийн эрүүл амьдрах дадал, хэвшилд үнэлгээ хийх:** Судалгаа эхэлж байна. Одоогоор 300 орчим айлд үнэлгээ хийгдсэн, зөвлөмж өгч сайжруулан жилийн турш хийгдэнэ.
7. **“Инээмсэглэл-ажлын байрны стандарт” эмнэлэг бүр төлөвшүүлэх:** Удирдамж боловсруулан, 9 сард дүгнэхээр ажиллаж байна. ЭМЯ-ны Ёс зүйн хорооноос сургалт авч сувилагч тусгай мэргэжилтнүүд 281 (80%) хамрагдсан.
8. **Сувилагч, эх баригч мэргэжлийг сурталчлах:** Сувилагч, эх баригч мэргэжлийн 25 ангид сурталчилж, 12 хүүхэд сувилагч, тусгай мэргэжлийн сонгон, эмнэлгүүд дээр сувилагчаар ажиллуулан мэргэжилтэйгээ танилцуулж, дурсгалын зүйл гардуулсан.
9. **Ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах:** “Чадамжтай баг-чадавхтай тусламж” аймгийн ажил мэргэжлийн 4-р уралдааныг 5 мэргэжлийн 140 хүнийг хамруулан зохион байгуулж, мэргэжлийн мэдлэгийн түвшин 76%, мэргэжлийн ур чадвар 6 өртөөгөөр шалгахад ур чадвар 87%-д хүрч өнгөрсөн оноос 8% дээшилсэн.
10. **Сувилахуйн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах:** 9 илтгэл 3 бүлгээр хэлэлцүүлсэн, улсын уралдаанд 3 удаа 8 хүн оролцож, номонд 5 судалгаа хэвлэгдсэн.
11. **Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн гадаад, дотоодын сургалтад хамруулах:** БНХАУ Алша аймагт 5 уламжлалт анагаах ухааны бага эмч, сувилагчийг 10 хоногийн сургалтад хамруулан, ажлын байран дээрх өөрчлөлт, шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулан ажиллуулж байна. АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн багш шавийн уулзалт зохион байгуулж 6 доктор, магистр багш нарын сургалтад 90 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.

Тайлан гаргасан: ЭМГ-ын сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн Д.Дүүмаам.